



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 27 өдөр

Дугаар Д/III

Хэрлэн сум

Төрийн байгууллагыг төвийн  
инженерийн шугамд холбох ажлын  
хэсэг байгуулах тухай

“Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дүгээр зүйлийн 60.1.12, “Барилгын тухай” хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.3, 35.1.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баян-Овоо, Батноров, Норовлин, Дадал, Өмнөдэлгэр, Цэнхэрмандал, Дэлгэрхаан, Баянмөнх, Бор-Өндөр, Галшар суманд инженерийн шугам сүлжээ, ариутгах татуурга цэвэрлэх байгууламжийн ажил хийгдсэнтэй холбоотойгоор сумдын зарим төрийн байгууллагыг төвийн инженерийн шугамд холбох ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Э.Мөнх-Эрдэнэ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Б.Оюундарь	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн
Гишүүд:	Ш.Ариунболор	Аймгийн ерөнхий архитектор
	М.Хишигбаяр	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга
	Д.Баттулга	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын барилгын техникийн улсын байцаагч
	Д.Эрхэмбаяр	“Хэнтий Ус” ХХК ерөнхий инженер
	Ө.Ганзориг	Онцгой байдлын газрын Гал түймрийн хяналтын улсын байцаагч
		Сумын Засаг дарга нар

2.

Н.Солонго	“Хайдродизайн прожект” ХХК захирал (зөвшилцсөнөөр)
Г.Баасандорж	“Онолт од” ХХК инженер (зөвшилцсөнөөр)
Н.Ямпил	“Инж байгууламж” ХХК захирал (зөвшилцсөнөөр)
Д.Бямбадорж	“Хангай илч дулаан” ХХК захирал (зөвшилцсөнөөр)

2.Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамжийг хавсралтаар баталсугай.

3.Сумдын төрийн байгууллагыг төвийн инженерийн шугамд холбох ажлыг журмын дагуу зохион байгуулж, дүнг танилцуулахыг ажлын хэсгийн дарга (Э.Мөнх-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

## АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

### Нэг. Зорилго

Баян-Овоо, Батноров, Норовлин, Дадал, Өмнөдэлгэр, Цэнхэрмандал, Дэлгэрхаан, Баянмөнх, Бор-Өндөр, Галшар суманд инженерийн шугам сүлжээ, ариутгах татуурга цэвэрлэх байгууламжийн ажил хийгдсэнтэй холбоотойгоор тус сумдын төвийн шугамд холбогдоогүй төрийн байгууллагатай танилцаж, холбох боломжийг судалж, үзлэг хяналт хэрэгжүүлэн зураг төсөв гаргуулан 2025 оны Улсын болон орон нутгийн төсөвт тусгах зураг төсвийг бэлэн болгоход оршино.

### Хоёр. Хугацаа

1.2024 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн 16 цагт ажлын хэсгийн хурал хийх

2.2024 оны 03 дугаар сарын 05-07-ны өдрийн хооронд Баян-Овоо, Батноров, Норовлин, Дадал, Өмнөдэлгэр, Цэнхэрмандал, Дэлгэрхаан сумд, 03 дугаар сарын 08-09-ны өдрийн хооронд Баянмөнх, Бор-Өндөр, Галшар сумд руу газар дээрх үзлэг хяналт хэрэгжүүлж, хийх ажлыг тодорхойлох

3.2024 оны 03 дугаар сарын 11-ны өдөр 16 цагт хурал хийж газар дээрх үзлэгийн ажлын тоо хэмжээг нэгтгэн тайлан боловсруулах

### Гурав. Хамрах хүрээ

Баян-Овоо, Батноров, Норовлин, Дадал, Өмнөдэлгэр, Цэнхэрмандал, Дэлгэрхаан, Баянмөнх, Бор-Өндөр, Галшар сум

### Дөрөв. Баримтлах зарчим

4.1 Сумдын төрийн байгууллагуудыг бүрэн хамруулах

4.2 Ажлын хэсгийн санал дүгнэлт холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

4.3 Ажлын хэсэг мэргэжлийн байгууллагын дүгнэлтэд /улсын байцаагчийн/ үндэслэн санал дүгнэлт гарч болно.

4.4 Хууль тогтоомж, бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтод нийцээгүй, холбогдох дүрэм журам стандартаар тавигдах шаардлагуудыг хангаагүй тохиолдолд хүсэлт гаргагчийн саналыг хүчингүйд тооцно.

4.5 Ажлын хэсэг санал дүгнэлтээ Аймгийн Засаг даргад танилцуулна.

### Тав. Хүрэх үр дүн

Баян-Овоо, Батноров, Норовлин, Дадал, Өмнөдэлгэр, Цэнхэрмандал, Дэлгэрхаан, Баянмөнх, Бор-Өндөр, Галшар суманд инженерийн шугам сүлжээ, ариутгах татуурга цэвэрлэх байгууламжийн ажил хийгдсэнтэй холбоотойгоор тус сумдын бүх төрийн байгууллага төвийн инженерийн шугам сүлжээнд холбогдох зураг төсөвтэй болсон байна.

Жич: Өөрийн зардлаар төвийн шугамд холбуулах ААН-ийн судалгаа гаргах, танилцах

УДИРДАМЖ БОЛОВРУУЛСАН:  
ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ  
ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Б.ОЮУНДАРЬ